



ОРХОН АЙМАГ  
БАЯН-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 01 өдөр

Дугаар 8/62

Баян-Өндөр сум

Г Хүрэнбулаг баг. 4-р сургуульд шаардлагатай  
сургалтын тоног төхөөрөмж, бараа материал  
хүлээн авах комисс байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн 160 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.3.4-т заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар “Хүрэнбулаг баг. 4-р сургуульд шаардлагатай сургалтын тоног төхөөрөмж, бараа материал” хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:

Ц.Болдсүх (4-р сургуулийн Захирал)

Гишүүд:

Д.Саранцэцэг (4-р сургуулийн Нягтлан бодогч)

Д.Цогт (4-р сургуулийн Аж ахуйн нярав)

Г.Бүрэнцогт (4-р сургуулийн Мэдээлэл зүйн багш)

Э.Энхчимэг (Орон нутгийн өмчийн газрын Хөрөнгийн бүртгэл, мэдээлэл хариуцсан мэргэжилтэн)

Х.Одхүү (Худалдан авах ажиллагааны газрын Хуулийн мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:

Ж.Давааням (Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын Хот төлөвлөлт, хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн)

2. Нийлүүлэгдэж буй тоног төхөөрөмжний техникийн тодорхойлолт, гэрээний хавсралтад заагдсан үзүүлэлтүүдийн дагуу хянаж, холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн хүлээн авч, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг хүлээн авах комисс (Ц.Болдсүх)-д даалгасугай.

3. Хүлээн авсан тоног төхөөрөмжийг 4-р сургуулийн хөрөнгө орлогод хүлээн авч, бүртгэн ажиллахыг Нягтлан бодогч (Д.Саранцэцэг)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.БААСАНСҮРЭН

6124010032